



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 25.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.10 дахь заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад олгох зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг тооцож, жил бүрийн төсвийн төсөлд тусгахыг Үндэсний аудитын Тамгын дарга (Албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бундхорол), аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шинэчлэн баталсан журмыг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Тамгын дарга (албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бундхорол)-д даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудитын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2022 оны 19 дугаар сарын 19-ны өдрийн
19 дугаар тушаалын... хавсралт

A/39

9006109
9019120396

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгоход энэ журмыг баримтална.

Хоёр. Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох

2.1. Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.4, 25.5 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллагын албан тушаал нь доор дурдсан зэрэг дэвтэй байх бөгөөд Төрийн аудитын байгууллагын албан хаагчид дор дурдсан байдлаар олгоно.

Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Хамаарах албан тушаал
Шадар түшээ	- Тэргүүн зэрэг - Дэд зэрэг - Гутгаар зэрэг - Дөтгөөр зэрэг	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч
Итгэмжит түшээ	- Тэргүүн зэрэг - Дэд зэрэг - Гутгаар зэрэг - Дөтгөөр зэрэг	Үндэсний аудитын газрын Тамгын дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн газрын захирал (дарга), тэргүүлэх аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Зөвлөх түшээ	- Тэргүүн зэрэг - Дэд зэрэг - Гутгаар зэрэг - Дөтгөөр зэрэг	Үндэсний аудитын газар, нийслэл дэх Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, менежер, аймаг дахь Төрийн аудитын газрын менежер
Ахлах түшээ	- Тэргүүн зэрэг - Дэд зэрэг - Гутгаар зэрэг - Дөтгөөр зэрэг	Төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч
Түшээ	- Тэргүүн зэрэг - Дэд зэрэг - Гутгаар зэрэг - Дөтгөөр зэрэг	Төрийн аудитын байгууллагын аудитор, шинжээч

2.2. Төрийн аудитын шадар түшээ, итгэмжит түшээ, зөвлөх түшээ, ахлах түшээ, түшээгийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Үндэсний аудитын газрын Тамгын даргын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр жилд нэг удаа олгоно.

2.3. Төрийн аудитын байгууллагын албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг уг албан хаагчийн шууд харьяалан удирдах эрх бүхий албан тушаалтан хавсралт маягтын дагуу гаргана.

2.4. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод заасан туршлагын шаардлага, төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг хангасан, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, үр дүнг үнэлэх журам”-ын 4.7.3 дахь заалт, 4.8, 4.18 дахь хэсэгт заасан “хандлага, ёс зүй”-н үнэлгээг тус тус үндэслэн төрийн аудитын байгууллагын албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг дор дурдсанаар шинээр болон ахиулан олгоно.

Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Ажилласан хугацаа /жилээр/		
		Төрийн албанд	Өмнөх ангилалд /Албан тушаалын тодорхойлолтод заасан туршлагын шаардлага/	Тухайн ангиллын албан тушаалд
Шадар түшээ	Тэргүүн зэрэг	16-аас доошгүй жил	төрийн аудитын зөвлөх түшээ эсхүл төрийн захиргааны эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 8-аас доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Итгэмжит түшээ	Тэргүүн зэрэг	16-аас доошгүй жил	төрийн аудитын ахлах түшээ эсхүл төрийн захиргааны ахлах түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Зөвлөх түшээ	Тэргүүн зэрэг	12-аас доошгүй жил	Төрийн аудитын түшээ эсхүл төрийн захиргааны дэс түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Ахлах түшээ	Тэргүүн зэрэг	8-аас доошгүй жил	Төрийн аудитын түшээ эсхүл төрийн захиргааны дэс түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Түшээ	Тэргүүн зэрэг	Төрийн албанд эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил		7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш

2.5. Төрийн аудитын байгууллагын албан тушаалд анх томилогдсон болон байгууллага дотроо албан тушаалд дэвшиж томилогдсон албан хаагч уг албан тушаалын ангилалд 1-ээс доошгүй жил ажилласны дараа энэ журмын 2.4 дэх хэсэгт заасан шалгуурыг хангаж байвал тухайн ангиллын албан тушаалын дөтгөөр зэргийг шинээр олгож, зэрэг дэвийг ахиулан олгох зарчим баримтална. Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэвийг хугацаанаас нь өмнө болон алгасаж олгохгүй бөгөөд тухайн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин 2 жил дараалан “Бүрэн хангалттай” (90-100 оноо), “Хангалттай” (70-89 оноо) үнэлэгдсэн тохиолдолд зэрэг дэвийг ахиулан олгоно.

2.6. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасны дагуу хугацаанаас өмнө шатлан дэвшиж томилогдсон төрийн аудитын байгууллагын албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг олгохдоо Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг харгалзан төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацааг (50 хувь) хангасан, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, үр дүнг үнэлэх журам”-ын 4.7.3 дахь заалт, 4.8, 4.18 дахь хэсэгт заасан “хандлага, ёс зүй”-н үнэлгээг тус тус үндэслэн албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг дор дурдсанаар шинээр болон ахиулан олгоно.

Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэг дэв	Ажилласан хугацаа /жилээр/		
		Төрийн албанд	Өмнөх ангилалд /Албан тушаалын тодорхойлолтод заасан туршлагын шаардлага/	Тухайн ангиллын албан тушаалд
Шадар түшээ	Тэргүүн зэрэг	8-аас доошгүй жил	төрийн аудитын зөвлөх түшээ эсхүл төрийн захиргааны эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Итгэмжит түшээ	Тэргүүн зэрэг	8-аас доошгүй жил	төрийн аудитын ахлах түшээ эсхүл төрийн захиргааны ахлах түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 2-оос доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Зөвлөх түшээ	Тэргүүн зэрэг	6-аас доошгүй жил	Төрийн аудитын түшээ эсхүл төрийн захиргааны дэс түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 2-оос доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш
Ахлах түшээ	Тэргүүн зэрэг	4-өөс доошгүй жил	Төрийн аудитын түшээ эсхүл төрийн захиргааны дэс түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 2-оос доошгүй жил	7 ба түүнээс дээш
	Дэд зэрэг			5 ба түүнээс дээш
	Гутгаар зэрэг			3 ба түүнээс дээш
	Дөтгөөр зэрэг			1 ба түүнээс дээш

2.7. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас Төрийн аудитын байгууллагад шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тохиолдолд тухайн албан хаагчийн өмнөх албан тушаалын зэрэг дэвийг Төрийн аудитын байгууллагын тухайн албан тушаалын ангилалд тохирох зэрэг дэвийг дүйцүүлж, бууруулахгүй олгоно.

2.8. Төрийн аудитын байгууллагын албан хаагчаас өөрөөс нь үл хамаарах шалтгааны улмаас албан тушаал буурсан тохиолдолд тухайн албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг бууруулахгүй.

2.9. Энэ журмын 2.8 дахь хэсэгт зааснаас бусад шалтгааны улмаас албан тушаал буурсан тохиолдолд тухайн албан тушаалын ангилалд хамаарах зэрэг дэв түүний нэмэгдлийг-олгоно.

Гурав. Зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ

3.1. Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл хөлсийг тухайн албан хаагчийн албан тушаалын цалингаас дор дурдсан хувиар тооцож сар бүр олгоно.

Албан тушаалын ангилал	Зэрэг дэвийн нэмэгдэл /хувиар/			
	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөөр зэрэг
Төрийн аудитын Тэргүүн түшээ	48	47	46	45
Төрийн аудитын Шадар түшээ	44	43	42	41
Төрийн аудитын Итгэмжит	40	39	38	37
Төрийн аудитын Зөвлөх түшээ	36	35	34	33
Төрийн аудитын Ахлах түшээ	32	30	28	26
Төрийн аудитын Түшээ	24	22	20	18

Дөрөв. Зэрэг дэвийг хэвээр хадгалах, хүчингүйд тооцох, олгохгүй байх.

4.1. Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэгт заасан төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй иргэн, мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтын дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэн Төрийн аудитын байгууллагын албан тушаалд хуулийн хүрээнд томилогдсон бол төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэвийг хэвээр, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг дүйцүүлэн олгоно.

4.2. Төрийн аудитын байгууллагад туршилтын хугацаагаар болон албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан хаагчид зэрэг дэв олгохгүй.

4.3. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноор эсхүл сахилгын шийтгэл хүлээж төрийн аудитын байгууллагын албан тушаалаас халагдсан албан хаагчийн зэрэг дэвийг ажлаас халсан өдрөөс эхлэн хүчингүйд тооцно.

4.4. Төрийн аудитын байгууллагын албан хаагчид дараах тохиолдолд албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгохгүй.

4.4.1. Зэрэг дэв олгох хугацааны шалгуурыг хангасан боловч төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин хангалтгүй үнэлэгдсэн;

4.4.2. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн, сахилгын шийтгэлтэй хугацаа дуусаагүй.

Тав. Албан тушаалын зэрэг дэвийг хэрэглэх

5.1. Төрийн аудитын байгууллагын албан тушаал эрхэлж байгаа албан хаагч албан тушаалын зэрэг дэвийг дор дурдсан байдлаар хэрэглэж болно:

5.1.1. албан бичиг, захидал харилцаанд;

5.1.2. албан ажлын өрөөний хаяг, нэрийн хуудаст;

5.1.3. хурал, цуглаан, уулзалт, хүлээн авалтын танилцуулгад.

ЗӨВШӨӨРСӨН:
 МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР (.....)

ЗЭРЭГ ДЭВ ОЛГУУЛАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

.....оны.....дугаар сарын-ны өдөр

1. газрын газар /хэлтэс/-ын аудиторнд Төрийн аудитын зэрэг дэв олгуулахаар танилцуулж байна.

2. Төрсөн огноо

3. нас

4. Хүйс:

5. Гэр бүлийн байдал

6. Боловсрол, мэргэжил, мэргэшил, эрдмийн зэрэг, цол:

7. Ажлын туршлага :

№	Байгууллага, нэгжийн нэр	Эрхэлсэн байсан албан тушаал	Томилогдсон чөлөөлөгдсөн огноо
1			
2			
3			
4			
5			
6			
7			

8. Тангараг өргүүлсэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн огноо, дугаар

9. Ажилласан хугацаа (жилээр):
 -Улсад ажилласан
 -Хувийн хэвшилд
 -Төрийн албанд
 -Захиргааны албанд
 -Төрийн аудитын байгууллагад
 -Тухайн албан тушаалд

10. Албан хаагчийн одоогийн зэрэг дэв (олгосон албан тушаалтан, шийдвэрийн огноо, дугаар)

11. Албан хаагчид олгуулахаар санал болгож буй албан тушаалын зэрэг дэв:

12. Албан тушаалын зэрэг дэв олгох шаардлагыг хангасан: үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ (дүн) дүгнэгдсэн.

ШУУД ХАРЬАЛАН УДИРДАХ
 НЭГЖИЙН ЗАХИРАЛ (ДАРГА)
 (тамга, тэмдэг)

(.....)